

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 793/21/15

Улаанбаатар хот

### Хувьцаа буцаан худалдан авах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 49.1, 76.1.6, 76.1.7 дах заалт, Компанийн дүрмийн 8.12.8, 8.12.15 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021.09.10-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь даатгал ХК-ийн нийтэд арилжаалагдсан хувьцаанаас нийт 250,000,000 төгрөгийн хувьцааг 2021 онд багтаан нээлттэй зах зээлээс буцаан худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа буцаан худалдан авах, түүнтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт олгосугай.
3. Тогтоолын төсөл бэлтгэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ө.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

## “БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 дугаар сарын 10

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал 2021 оны 09-р сарын 10-ны өдрийн 10:00 цагаас Цахимаар хуралдан 10:40 цагаас дуусав. ТУЗ-ийн дарга Л.Болджуяг, гишүүн Г.Саруул, Б.Билэгт, Ш.Сүхбаатар, Ш.Бэжид, Д.Даянбилгүүн, Хараат бус гишүүн Э.Бямбажав, Б.Бүжинлхам, Б.Эрдэнэбат Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, ТУЗ-н нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй болов.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Бодь даатгал ХК-ийн нийтэд арилжаалагдсан хувьцаанаас нийт 250,000,000 төгрөгийн хувьцааг 2021 онд багтаан нээлттэй зах зээлээс буцаан худалдан авах тухай.

Б.Золбаяр: Богд банк нь IPO гаргахад хөрөнгө оруулагч болж оролцсон. Цаашид хувьцаа өсөх ирээдүйтэй гэж үзэж байгаа боловч, одоогийн байдлаар банкны хувьцаа эзэмших хязгаарууд тулсан тул зах зээлд нийлүүлэх шаардлага байгаа. Хөрөнгийн зах зээлийн эрэлт 500-600 сая төгрөгийг богино хугацаанд шингээх боломжгүй байна. Тиймээс их хэмжээгээр нийлүүлэх нь хувьцааны үнэд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байгаа тул, нийтэд арилжаалагдсан хувьцаанаас 250,000,000 төгрөгийн хувьцааг буцаан худалдан авах саналтай байна. Компанийн тухай хуулийн дагуу зах зээлд байгаа ойролцоогоор 35 сая ширхгийн 25%-иас дээш буюу 8.75 сая ширхэг хувьцаанаас дээш худалдан авах бол нийтэд зарлаж, бүх хувьцаа эзэмшигч нараас хувь тэнцүүлэн авахаар заасан байдаг боловч санал болгож байгаа хувьцаа нь энэ дүнд хүрэхгүй байгаа тул хувьцааг буцаан худалдан авах санал оруулж байна.

Гишүүд 100 хувь дэмжив.

### **Шийдвэрлэсэн нь:**

1. Бодь даатгал ХК-ийн нийтэд арилжаалагдсан хувьцаанаас нийт 250,000,000 төгрөгийн хувьцааг 2021 онд багтаан нээлттэй зах зээлээс буцаан худалдан авахыг зөвшөөрөв.
2. Хувьцаа буцаан худалдан авах, түүнтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт олгов.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан :

ТУЗ-ийн дарга	Л.Болдхуяг /...../
ТУЗ-ийн гишүүд:	Г.Саруул /...../
	Б.Билэгт /...../
	Ш.Сүхбаатар /...../
	Д.Даянбилгүүн /...../
	Ш.Бэжид /...../
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Э.Бямбажав /...../
	Б.Эрдэнэбат /...../
	Б.Бүжинлхам /...../
Хурлын тэмдэглэл хөтөлсөн:	Ө.Батчимэг /...../